



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН
ЧУУЛГЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Н.ГАНТУЛГА ТАНАА

2017.02.20 № 3/274

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0220SAG53.Docx

070235



ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:

Аудитын тайлан

САГазрын дарга,
тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 263533
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

АГУУЛГА

Аудитын менежер Н.Золзаяа
Утас: 260512
Цахим хаяг: zolzaya@audit.gov.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг:
serjmyadag@audit.gov.mn

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Монгол Улсын
Үндэсний аудитын газар:
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6
Вэб хуудас: www.audit.mn

“Мэдээлэл-Аудит” ХХК
БГД, 17-р хороо,
Амарсанаагын гудамж
JSD төв, 505, 506 тоот
Захирал: Д.Товуудорж
Утас: 369511
Вэб хуудас: medeelelaudit@gmail.com

АГУУЛГА

1	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	2
2	Байгууллагын хууль, эрх зүйн орчин	2
3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	3
4	Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	3
5	Дотоод хяналт	4
6	Материаллаг түвшин	4
7	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	4
8	Шилэн дансны мэдээлэл	5
9	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар	5
10	Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	5
11	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	5
12	Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	6
13	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	6
14	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
15	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
16	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	6
17	Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт	6
18	Менежментийн захидал	7-9
19	Аудитлагдсан санхүүгийн тайлан	10-15
20	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
21	Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан	17

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дах заалтыг үндэслэн төрийн аудитын тухай хуулийн 18.3 дугаар зүйлд заасан Үндэсний Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд **ҮАГ-САГ/2017/157/СТА-ТШЗ** аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 17-наас 2 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн, “Мэдээлэл Аудит” компанийн ахлах аудитор Д.Товуудоржоор удирдуулсан аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

ЦДБЭЧ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 17 –ны өдөр "Мэдээлэл-Аудит" ХХК –д ирүүлсэн. "Мэдээлэл-Аудит" ХХК нь Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 17 –ны өдрөөс 2017 оны 2 дүгээр сарын 15–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 20 –ний өдөр Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль,

Нийгмийн даатгалын багц хууль, Татварын багц хууль болон “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” ЗГ-ын 2014 оны №75, 208, 78 тогтоол, “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” ЗГ-ын 2011 оны №311 тогтоол гэх мэт хууль тогтоомж холбогдох дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Цэргийн дуу бүжгийн Батлан хамгаалах яамны бодлого, зэвсэгт хүчний зорилт үйл ажиллагааг тоглолт үйлчилгээ, соёлын арга хэмжээгээр цэргийн хүрээний анги нэгтгэл ард иргэдэд хүргэн сурталчилж, цэргийн соёл урлагыг бүхий л талаар нь дэмжин хөгжүүлж, олон нийтэд хүргэх менежментийг боловсронгуй болгон гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын Ерөнхий захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны төсвийг Батлан хамгаалах яамны Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлэн ажилласан.

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 5-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад УСНББОУС-тай нийцсэн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх НБББББ-ийг боловсруулан байгууллагын даргын 2013 оны 190 тоот тушаалаар баталж, 2014 оны 1-р сарын 1-ээс эхлэн мөрдөн ажиллаж, санхүүгийн тайлангаа холбогдох аргачиллын дагуу, санхүүгийн программаар боловсруулан бэлтгэжээ.

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга”-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Материаллагын түвшин

Мөн материаллаг түвшинг төлөвлөлтийн үед төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлээрх нийт зардал 1 640,1 сая төгрөгийн 1 хувь 16,4 сая төгрөгөөр авсан тул гүйцэтгэлээр мөн нийт зардал 1 690,1 сая төгрөгийн 1 хувиар авахад 16,9 сая төгрөг байна. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг өөрчлөөгүй болно.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбар яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс 1 495,1 сая төгрөгийн санхүүжилт авахаар төсөвлөгдсөнөөс 1 547,4 сая төгрөг буюу 2%-иар илүү санхүүжилт авч, өөрийн үйл ажиллагаагаар 61,4 сая төгрөгийн орлого олохоор төсөвлөснөөс 34,3 сая төгрөгийн орлого олж 45%-ийн биелэлттэй ажилласан байна. Мөн тусгай үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготой 50,0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч нийт 1 631,6 сая төгрөгийн мөнгөн орлогын хүрээнд үйл ажиллагаагаа явуулжээ.

Төсөвлөсөн зардал 1 609,5 сая төгрөг байсан нь 98% буюу 1 581,6 сая төгрөгийн биелэлттэй байна. Үүнээс 1 429,2 сая төгрөг буюу 90% нь цалин, НДШ-ын зардал байна.

Нэмэлт санхүүжилт 50,0 сая төгрөгийг Ю.Цэдэнбал агсаны мэндэлсэний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний тайз заслыг хийж гүйцэтгэхэд зориулж 20.0 сая төгрөг, “Улаанбаатарын намар” арга хэмжээний тайз заслын төлбөрт 30.0 сая төгрөг тус тус зарцуулсан.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудсанд 2016 оны батлагдсан төсөв, 2016 оны сар бүрийн төсөв гүйцэтгэлийн тайлан, захирлын тушаалуудыг шивж оруулсан төдийгүй файлаар хавсаргасан байна. 5.0 сая төгрөгнөөс дээш дүнтэй зардлын мэдээллийг шилэн дансанд оруулсан байна. Холбоос: <https://www.shilendans.gov.mn/org/1037?group=0&year=2016>

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

ЦДБЭЧ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлсний тооцоо, түрээсийн орлого зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна

1. Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга нь цайны газар түрээслүүлэн ажиллуулж 2,5 сая төгрөгийн орлого олсноос ТӨХ-ны 2007 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн №42 тоот тогтоолын 2в-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлсэнээс олсон орлогын 20 хувийг ТӨХ-ны Төрийн сангийн дансанд сар бүр төвлөрүүлж, улирал, жилийн эцэст Төрийн өмчийн хороотой тооцоо нийлж акт үйлдэж байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад ТӨХ-ны Төрийн санд

0,5 сая төгрөгийг төвлөрүүлсэн

2. Үндсэн хөрөнгөнд Ордоны барилга, байгууламж, шугам сүлжээ зэрэг 216 нэр төрлийн 3 869.7 сая төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь ОБ, ИБ, ТИ, ҮЗ батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: ТӨБЗГазарт хандаж холбогдох арга хэмжээг авах

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Залруулагдаагүй алдаа байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Дараагын аудитаар анхаарч үзэх анхаарал татах асуудал үгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 0.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 0.5 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулан, үлдэгдэл өртөггүй 216 нэр төрлийн үндсэн хөрөнгийг ТӨБЗГазарт хандаж холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Мэдээлэл-Аудит”ХХК-аас 18.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авахдаа 2005 оны 12 сарын 01-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль, 2013 оны 03 сарын 02-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” ЗГ-ын №68 дугаар тогтоолыг баримтлаагүй буюу харьцуулалтын аргыг ашиглаагүй шууд худалдан авалт хийсэн тул цаашид зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөгдсөн бөгөөд энэ тайлант хугацаанд ийм ажил гүйлгээ гараагүй байна.

Аудитын санал дүгнэлт

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.



ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Үндсэн хөрөнгө 10

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1 Дээд шатны хяналт	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	----------------------------------

Аудитын ажиглалт

Аудитын зөвлөмж-1

- Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн Ордны барилга, байгууламж, шугам сүлжээ зэрэг 216 нэр төрлийн 3 869.7 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.

Холбогдох дээд байгууллагаараа шийдвэрлүүлэн дахин үнэлгээ хийлгэх

Эрсдэл

Үйлчлүүлэгчийн хариу

- Санхүүгийн хяналт алдагдаж
- хөрөнгө шамшигдах /У, Х, ТИ, ҮЗ, ЭҮ/
- НББОУС-16 зөрчигдөх

Зөвлөмжийн дагуу холбогдох дээд байгууллагад хүсэлт тавьж, шийдвэрлүүлэх талаар анхаарч ажиллана.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	<i>/төгрөгөөр/</i>	
Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0,00	0,00
АВЛАГА	0,00	0,00
БАРАА МАТЕРИАЛ	435 767 529,82	478 372 628,75
Түүхий эд материал	229 462 747,94	265 718 661,87
Тоглолтын хувцас, хэрэгсэл	13 845 930,00	22 599 930,00
Хангамжийн материал	120 332 066,85	119 989 801,85
Бусад	72 126 785,03	70 064 235,03
НӨӨЦИЙН БАРАА		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	435 767 529,82	478 372 628,75
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
Биет хөрөнгө	132 656 778,68	151 019 510,47
Барилга, байгууламж	3 453 722 060,00	3 453 722 061,00
Хуримтлагдсан элэгдэл	(3 453 722 060,00)	(3 453 722 059,00)
Авто-тээврийн хэрэгсэл	20 507 410,42	95 961 410,04
Хуримтлагдсан элэгдэл	(11 204 518,77)	(23 006 198,21)
Машин тоног төхөөрөмж /трансформатор/	119 879 745,61	121 579 745,61
Хуримтлагдсан элэгдэл	(88 687 128,52)	(104 631 576,60)
Тавилга, аж ахуйн эд хогшил	68 823 808,80	68 823 808,80
Хуримтлагдсан элэгдэл	(33 789 351,05)	(41 013 405,42)
Батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж	479 312 781,16	479 312 781,16
Хуримтлагдсан элэгдэл	(422 479 968,97)	(446 301 058,91)
Түүх соёлын дурсгалт зүйлс	294 000,00	294 000,00
Биет бус хөрөнгө		
Программ хангамж	940 170,00	940 171,00
Хуримтлагдсан элэгдэл	(940 170,00)	(940 169,00)
БУСАД ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	132 656 778,68	151 019 510,47
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	568 424 308,50	629 392 139,22
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0,00	0,00
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	0,00	0,00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0,00	0,00
ЭЗДИЙН ӨМЧ		
Засгийн газрын оруулсан капитал	1 512 129 265,25	1 512 129 265,25
Хуримтлагдсан үр дүн	(946 497 366,42)	(885 529 539,31)
Өмнөх үеийн үр дүн	(946 497 366,42)	(946 497 366,42)
Тайлант үеийн үр дүн		60 967 827,11
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2 792 409,67	2 792 409,67
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	568 424 308,50	629 392 135,61
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	568 424 308,50	629 392 135,61

СТ-2А

АУДИТ ХИЙГДСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төсвөөс	1 654 598 589,42	1 547 372 400,00
Урсгал	1 654 598 589,42	1 547 372 400,00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	390 059 793,55	203 674 578,18
Үндсэн үйл ажиллагааны орлого	44 841 400,00	21 616 200,00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	343 821 955,00	62 624 500,00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	1 396 438,55	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		119 433 878,18
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2 044 658 382,97	1 751 046 978,18
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	1 543 892 174,02	1 429 200 344,00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	1 444 222 074,02	1 332 388 244,00
Цалин	1 444 222 074,02	1 290 645 444,00
Цалингийн тусгай нэмэгдлүүд		41 742 800,00
Нийгмийн даатгал	99 670 100,00	96 812 100,00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	71 822 900,00	70 394 100,00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	66 932 900,00	65 504 100,00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1 956 000,00	1 956 000,00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2 445 000,00	2 445 000,00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	489 000,00	489 000,00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	27 847 200,00	26 418 000,00
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	202 815 901,09	145 982 123,93
Тогтмол зардал	20 030 865,20	23 644 905,28
Гэрэл цахилгааны зардал		
Түлш, халаалтын зардал	17 760 850,00	20 121 390,00
Цэвэр, бохир усны зардал	2 270 015,20	3 523 515,28
Үйл ажиллагааны зардал	6 099 036,00	194 000,00
Хоолны зардал	5 901 236,00	0,00
Эмийн зардал	197 800,00	194 000,00
Бусад бараа, үйлчилгээний зардал	176 685 999,89	122 143 218,65
Бичиг хэргийн материал	9 707 470,00	957 991,00
Тээвэр, шатахууны зардал	32 182 472,00	17 278 000,00
Шуудан холбооны зардал	676 284,20	493 787,40
Дотоод албан томилолтын зардал	3 320 000,00	
Ном, хэвлэлийн зардал	771 500,00	
Хог хаягдал устгах, цэвэрлэх зардал	342 000,00	210 000,00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	6 853 957,50	6 820 185,00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	2 058 533,00	4 372 850,00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	51 467 467,23	25 730 064,25
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	240 000,00	150 000,00
Урсгал засварын зардал	16 323 576,91	7 182 650,00
Элэгдлийн зардал	49 690 640,05	58 791 271,00
Даатгалийн үйлчилгээний төлбөр		156 420,00
Аж ахуйн материал худалдан авах зардал	3 052 099,00	
Хөтөлбөр арга хэмжээний зардал	325 505 582,00	58 027 700,00
	80 452 582,00	58 027 700,00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		
Гадаад зочны зардал	245 053 000,00	
Төвлөрүүлэх шилжүүлэг		0,31
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	10 834 540,55	56 868 982,00

Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж		
Мөнгөн хэлбэрээр	10 834 540,55	56 868 982,00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	4 836 238,55	
Тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмж	5 998 302,00	56 868 982,00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2 083 048 197,66	1 690 079 150,24
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(38 389 814,69)	60 967 827,94
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	0,00	0,00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	0,00	0,00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(38 389 814,69)	60 967 827,94

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Татаас, санхүүжилтийн орлого	1 654 598 589,42	1 547 372 400,00
Улсын төсвөөс	1 654 598 589,42	1 547 372 400,00
Урсгал	1 654 598 589,42	1 547 372 400,00
Нийгмийн даатгалаас	7 886 074,00	0,00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	390 059 793,55	84 240 700,00
Төсвийн урамшуулал		
Үндсэн үйл ажиллагааны орлого	44 841 400,00	21 616 200,00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	343 821 955,00	62 624 500,00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	1 396 438,55	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2 052 544 456,97	1 631 613 100,00
Ажиллагсадтай холбогдсон зардал	1 528 675 400,00	1 429 200 344,01
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	1 429 005 300,00	1 332 388 244,01
Цалин	1 429 005 300,00	1 332 388 244,01
Нийгмийн хамгааллын шимтгэл	99 670 100,00	96 812 100,00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	71 822 900,00	70 394 100,00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	66 932 900,00	65 504 100,00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1 956 000,00	1 956 000,00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2 445 000,00	2 445 000,00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	489 000,00	489 000,00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	27 847 200,00	26 418 000,00
Бараа үйлчилгээний урсгал зардал	138 768 623,42	77 062 073,68
Тогтмол зардал	20 030 865,20	23 644 905,28
Гэрэл цахилгааны зардал		
Түлш, халаалтын зардал	17 760 850,00	20 121 390,00
Цэвэр, бохир усны зардал	2 270 015,20	3 523 515,28
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	21 387 799,02	261 200,00
Хоолны зардал	21 149 999,02	0,00
Эмийн зардал	237 800,00	261 200,00
Бусад бараа, үйлчилгээний зардал	97 349 959,20	53 155 968,40
Бичиг хэргийн материал	9 678 660,00	893 491,00
Тээвэр, шатахууны зардал	32 092 472,00	17 853 000,00
Шуудан холбооны зардал	676 284,20	493 787,40
Дотоод албан томилолтын зардал	3 320 000,00	
Ном, хэвлэлийн зардал	8 095 310,00	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгах	342 000,00	210 000,00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	5 552 600,00	3 062 870,00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	240 000,00	150 000,00
Жижиг эд хогшил худалдан авах зардал		
Жижиг эд хогшил худалдан авах /Тавилга/		
Жижиг эд хогшил худалдан авах /Бага үнэтэй/	2 058 533,00	3 108 500,00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	19 970 100,00	19 778 900,00
Төлбөр, хураамж, жижиг татварууд		
Даатгалын үйлчилгээний төлбөр	154 500,00	156 420,00
Урсгал засварын зардал	15 169 500,00	7 449 000,00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	335 151 082,00	66 781 700,31
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	335 151 082,00	66 781 700,31
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	90 098 082,00	66 781 700,00

Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	245 053 000,00	
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт		
Төвлөрүүлэх шилжүүлэг		0,31
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	18 103 940,55	56 868 982,00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	18 103 940,55	56 868 982,00
Мөнгөн хэлбэрээр	18 103 940,55	56 868 982,00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	4 836 238,55	
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн зардал	13 267 702,00	56 868 982,00
Нийгмийн даатгалаас олгосон тэтгэмж	7 886 074,00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	2 028 585 119,97	1 629 913 100,00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	23 959 337,00	1 700 000,00
Хөрөнгийн орлого /ХО-ийн санхүүжилт/		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Бусад хөрөнгийн борлуулалтын орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0,00	0,00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	23 959 337,00	1 700 000,00
Хөрөнгийн бусад зардал		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	23 959 337,00	1 700 000,00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(23 959 337,00)	(1 700 000,00)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0,00	0,00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0,00	0,00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0,00	0,00

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үрдүн	Нийт
2014 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1 512 129 265,25	2 792 409,67	(908 107 551,72)	606 814 123,20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(38 389 814,69)	(38 389 814,69)
2015 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1 512 129 265,25	2 792 409,67	(946 497 366,41)	568 424 308,51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 512 129 265,25	2 792 409,67	(946 497 366,41)	568 424 308,51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			60 967 827,10	60 967 827,10
2016 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1 512 129 265,25	2 792 409,67	(885 529 539,31)	629 392 135,61

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРСГАЛ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Батлан хамгаалахын сайдын багцад багтах Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

/төгрөгөөр/

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		0,00		
Төсвийн санхүүжилт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48 536 000,00	21 616 200,00	26 919 800,0	45%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12 859 600,00	12 624 500,0	235 100,0	98%
Төсвөөс санхүүжилт	1 495 073 000,00	1 547 372 400,0	(52 299 400,0)	103%
Төсөвийн орлогын дүн	1 556 468 600,00	1 581 613 100,00	(25 144 500,00)	102%
1 429 200 344,01				
Зардалын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1 332 397 600,00	1 332 388 244,01	9 355,99	100%
Үндсэн цалин	1 332 397 600,00	1 332 388 244,01	9 355,99	100%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96 812 100,00	96 812 100,00	-	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	180 298 200,00	152 412 755,68	27 885 444,32	85%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27 881 800,00	23 644 905,28	4 236 894,72	85%
Түлш халаалт	24 920 800,00	20 121 390,0	4 799 410,00	81%
Цэвэр, бохир ус	2 961 000,00	3 523 515,3	(562 515,28)	119%
Хангамж, бараа материал	24 921 300,00	22 558 778,40	2 362 521,60	91%
Бичиг хэрэг	894 700,00	893 491,00	1 209,00	100%
Тээвэр (шатахуун)	19 862 500,00	17 853 000,00	2 009 500,00	90%
Шуудан, холбооны зардал	637 100,00	493 787,40	143 312,60	78%
Ном хэвлэл авах	0,00	0,00	-	
Хог хаягдал устгах цэвэрлэх	626 000,00	210 000,00	416 000,00	34%
Бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2 901 000,00	3 108 500,00	(207 500,00)	107%
Норматвит зардал	23 655 000,00	20 040 100,00	3 614 900,00	85%
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	23 275 000,00	19 778 900,00	3 496 100,00	85%
Эм	380 000,00	261 200,00	118 800,00	69%
Эд хогшил худалдан авах зардал	13 034 900,00	9 299 000,00	3 735 900,00	71%
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	231 000,00	150 000,00	81 000,00	65%
Багаж, техник хэрэгсэл худалдан авах	-	1 700 000,00	(1 700 000,00)	
Урсгал засвар	12 803 900,00	7 449 000,00	5 354 900,00	58%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	28 246 500,00	16 938 120,00	11 308 380,00	60%
Дотоод албан томилолт	2 545 300,00	0,00	2 545 300,00	0%
Хичээл үйлдвэрийн дадлага	3 062 900,00	3 062 870,00	30,00	100%
Татаас ба урсгал шилжүүлэг	56 950 500,00	56 868 982,00	81 518,00	100%
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн зардал	56 950 500,00	56 868 982,00	81 518,00	100%
Төсөвт зардлын дүн	1 609 507 900,00	1 581 613 099,69	27 894 800,31	98%
Төвлөрүүлэх шилжүүлэг 0,31				
Мөнгөн хөрөнгийн нийт зарцуулалт	1 609 507 900,00	1 581 613 100,00		
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		0,00		

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/төгрөгөөр/

Төсвийн санхүүжилт	Аудитлагдсан
Тусгай үйл ажиллагааны санхүүжилт	50 000 000,00
Төсөвийн орлогын дүн	50 000 000,00

Зардалын нэр төрөл	Аудитлагдсан
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	50 000 000,00
Зардлын дүн	50 000 000,00

Нэмэлт санхүүжилтийн тайлбар:

1. “Улаанбаатарын намар” нэгдсэн арга хэмжээг Д.Сүхбаатарын нэрэмжит талбайд 2016-09-30-ны өдөр зохион байгуулахад зориулсан тайзны угсралт, буулгалт, тээвэрлэлт, менежментийн багын зардал, тээврийн зардалд зориулж “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл”ТӨҮГ-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний төлбөр 30.0 сая төгрөг,
2. Төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбал агсаны мэндэлсэний 100 жилийн ойн арга хэмжээний тоглолтын тайзны угсралт, буулгалт, менежментийн багын зардал, тээврийн зардалд зориулж “On’n Off Production”ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний санхүүжилт 20.0 сая төгрөг, нийт 50.0 сая төгрөг нэмэлт санхүүжилтээр төрийн сангаас орж ирж, гэрээний дагуу холбогдох дансанд шилжсэн байна.